



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2008 оны 09 сарын 17 өдөр

Дугаар 476

Улаанбаатар 03

Гадаадад зээлээр суралцуулах,
тушаалд өөрчлөлт оруулах тухай

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар батлагдсан "Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам", шалгалтын комиссын дүн, захиалагч байгууллагын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Халтмаа овогтой Энэбишийг Улсын Их Хурлын Тамгын газрын захиалгаар АНУ-ын Колорадогийн их сургуулийн магистрантурт эрүүгийн эрх зүйн чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Ганболд овогтой Энхбаярыг Эрүүл мэндийн яамны захиалгаар АНУ-ын Де Врай их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Цээпилдорж овогтой Болортуяаг Хүнс, хөдөө аж ахуйн яамны захиалгаар Сингапурын Raffles академийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Цогтжаргал овогтой Эрдэнэбулганыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар Австрали Улсын Сидней их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Бэгзсүрэн овогтой Мягмарсүрэнг Үндэсний статистикийн хорооны захиалгаар St. Patrick коллежийн магистрантурт удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Адъяахүү овогтой Сарантуяаг Улсын дээд шүүхийн захиалгаар California Western хуулийн сургуулийн магистрантурт эрх зүйн чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Жамъянчойжил овогтой Сэмжидийг Улсын дээд шүүхийн захиалгаар Австрали Улсын New South Wales их сургуулийн магистрантурт хуулийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Баатар овогтой Хүсэлбадрахыг Монголбанкны захиалгаар АНУ-ын Үндэсний их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Магвансүрэн овогтой Эрдэнэчулууныг Монголбанкны захиалгаар АНУ-ын Де Паул их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Мянганбуу овогтой Наранцогтыг Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн захиалгаар АНУ-ын Стратфорд их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Билэгсайхан овогтой Тэнгисийг Түлш, эрчим хүчний яамны захиалгаар АНУ-ын Европын эдийн засгийн сургуульд олон улсын бизнесийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Бадарч овогтой Хэрлэнг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар ХБНГУ-ын Потсдамын их сургуулийн докторантурт эдийн засаг, удирдлагын чиглэлээр 3 жилийн хугацаагаар, Пүрэвжал овогтой Цэрэндавааг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар ХБНГУ-ын Гёттингений их сургуулийн докторантурт экологи, байгалийн ухааны чиглэлээр 3 жилийн

00 1191

хугацаагаар тус тус 2008-2009 оны хичээлийн жилээс Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 401 дүгээр тушаалын Энхбаатар овогтой Мөнхмаралтай холбогдолтой хэсгийн "АНУ-ын Виржиния мужийн Жорж Майсоны их сургуулийн" гэснийг "АНУ-ын Стрейер их сургуулийн" гэж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 386 дугаар тушаалын Ням-Осор овогтой Алтантуяатай холбогдолтой хэсгийн "АНУ-ын Чикаго хотын Деврийн Их сургуулийн Келлерийн нэрэмжит менежментийн сургуулийн" гэснийг "АНУ-ын Зүүн Хойд Иллинойсын их сургуулийн" гэж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 295 дугаар тушаалын Даваадорж овогтой Тэлмэнтэй холбогдолтой хэсгийн "АНУ-ын Massachusetts технологийн сургуулийн" гэснийг "Харвардын их сургуулийн" гэж тус тус өөрчилсүгэй.

3. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.



Н.Болормаа

Н.БОЛОРМАА